



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

**Зардал батлах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын хил орчмын бүс нутагт ОХУ-тай хамтран тарваган тахал, хам тохиолдох зоонозын халдварт байгалийн голомтын тандалт судалгаа”-ны ажлыг удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Лавлагаа лабораторийн албаны Нян судлагч (О.Эрдэнэцэцэг)-д, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын албаны дарга (Х.Ариунболд)-д үүрэг болгосугай.

2.Тандалт судалгааны зардал болох 7,148,500 (долоон сая нэг зуун дөчин найман мянга таван зуун) төгрөгийг томилолт, тээвэр, шатахуун, холбогдох зардлаас тооцож гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (С.Мөнхчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (У.Нямжаргал)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АМГАЛАНБАЯР

